

# Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо

Тогтвортой хөгжлийн хөтөч

## NEAR

The Association of Northeast Asia Regional Governments



## Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо

(37668) Кёнсанбүг муж, Пухан хот Намгү Жигугну 394(Жигугдун 601)

Пухан Технопарк 3 давхарт

Tel: +82-54-223-2308, 2324 Fax: +82-54-223-2307

Email: near@neargov.org

[www.neargov.org](http://www.neargov.org)





## Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо(NEAR) бол

Зүүн хойд Азийн бүсийн 6 улсын засаг захиргааны томхон нэгж, өөрөөр хэлбэл муж, аймаг, бие даасан хотын гишүүнчлэлтэй харилцаа хамтын ажиллагааны орон нутгийн байгууллага юм.

Тус Холбоо 1996 онд байгуулагдснаас хойш Хятад, Япон, Өмнөд Солонгос, Монгол, Хойд Солонгос, Орос улсын 78 орон нутаг гишүүнээр элссэн бөгөөд Зүүн хойд Азийн 666 сая хүн амыг хамрах болсон юм.

Мөн Вьетнам улсын Хошимин хот сурвалжлагч гишүүнээр элссэн бөгөөд 5 ажиглагч орон нутаг, олон улсын 3 байгууллага(AER, R20, ICLEI)-тай түншлэлийн харилцаа тогтоон хамтран ажиллаж байна.

## The Association of Northeast Asia Regional Governments

### Зорилго

#### Холбооны үндсэн дүрмийн 1-р бүлгийн 2-р зүйл

"Харилцан ашигтай, тэгш эрхийн үндсэн дээр байгуулагдсан тус "Холбоо" нь Зүүн хойд Азийг хамтдаа хөгжүүлэх төдийгүй гишүүн орон нутгийн захиргааны байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааны сүлжээг байгуулж, харилцан ойлголцолд үндэслэсэн итгэлцлийг бий болгож, улмаар дэлхийн энхтайвны үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг зорилго болгоно".

#### Холбоог үүсгэн байгуулах хурал (1996 он)



#### ХОЛБООНЫ АЖЛЫН ХОРООНЫ АНХДУГААР ХУРАЛ (1997 ОН)



Мэдээлэл харилцаа, зам тээвэр хөгжиж, улс төрийн хурцадмал байдал зөөлөрснөөр улс хоорондын харилцаа идэвхжин орон нутгийн нягт хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлснээр (Regionalization) улсын өрсөлдөх хүчийг нэмэгдүүлж, бүс нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх цаг үе ирээд байна.

Түүх, газарзүйн нягт уялдаан дээр хөгжих хязгааргүй их боломжтой, 21-р зуунд дэлхийн эдийн засгийн гуравдагч тэнхлэг болж буй энэхүү бүсийн харилцаа, хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлэх Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоог байгуулах болсон билээ.

## Эрхэм зорилго &amp; Үндсэн зарчим

АЛСЫН  
ХАРАА

Зүүн хойд Азийн бүсийн хамтын  
хөгжил рүү тэмүүлэхийн зэрэгцээ  
дэлхийн энх тайвны үйлсэд хувь нэмэр  
оруулна.

ЭРХЭМ  
ЗОРИЛГО

- NEAR Холбоо бүс нутгийн эв нэгдлийг бэхжүүлэн тэнцвэртэй хөгжлийн стратеги, мэргэжлийн мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох, хүүхэд залуучуудыг харилцааны үйл ажиллагаанд татан оролцуулах зэргээр **Зүүн хойд Азийн харилцааг идэвхжүүлэх**
- болон хамтын хөгжлийн бодит арга замыг эрэлхийлэх ба түншлэлийн харилцааг өргөжүүлж **олон улсад Зүүн хойд Азийн**
- **өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд** хувь нэмэр оруулна.

ЭРХЭМ  
ЗОРИЛГО


Зорилгодоо хүрэхийн тулд:

- эрх тэгш
- харилцан ашигтай
- итгэлцэл хүндлэл
- харилцаа хамтын ажиллагааны зарчмыг баримтлан энх тайван, хөгжил дэвшил рүү тэмүүлнэ.

## Бүтэц, зохион байгуулалт

## Бүгд хурал(Тэргүүлэгч орон нутаг)

Гишүүн орон нутгийн засаг дарга, захирагч нараас бүрдэх шийдвэр гаргах дээд байгууллага ба 2 жил тутамд хуралдаж, Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, гишүүнээр элсүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.



## Ажлын хэсгийн хороо

Гишүүн орон нутгийн тамгын газар, захирагчийн ажлын албаны дарга нараас бүрдэх ба Бүгд хуралд санал дэвшүүлэх, ажлын төлөвлөгөө, төслийг хэлэлцэх, салбар хороо байгуулах, хороодыг нэгтгэх зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

## Салбар хороо

Бүсийн харилцааг хөгжүүлэхэд салбар бүрээр үйл ажиллагаа явуулах ба хорооны зохицуулагчаар гишүүн орон нутгийн захиргаа ажиллана.

Холбооны Хэрэг  
эрхлэх газар(Ерөнхий  
нарийн бичгийн  
дарга)

Бүгд хурал, Ажлын хэсгийн хорооны хурал, салбар хороодын хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, NEAR олон улсын форум, Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, NEAR Залуучуудын форум, Хүүхэд сурагчдад зориулсан эссэ бичлэгийн уралдаан зэргийг зохион явуулахаас гадна NEAR News сэтгүүл, Холбооны жилийн үйл ажиллагааны тайлан, Холбооны түүхэн эмхэтгэл гаргах болон вэбсайт ажиллуулдаг.



## Чиг үүрэг

### Бүгд хурал

Гишүүн болон сурвалжлагч гишүүн элсүүлэх, гишүүнээс түдгэлзүүлэх, гишүүний татварын асуудлыг шийдвэрлэх, Үндсэн дүрмийн агуулгад өөрчлөлт оруулах, Холбоог татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох асуудлыг шийдвэрлэх, аудиторуудыг томилох, төсөл тайлан баланс, ажлын төлөвлөгөөг батлах, гишүүний татвар зарцуулалтын журмаар заасан зүйлийг батлах, дараагийн Бүгд хурлыг зохион байгуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, Холбооны ажлын төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэгтэй.

### Ажлын хэсгийн хороо

Шинээр хийх ажлыг төлөвлөх, төслийн талаар хэлэлцэх, жилийн болон санхүүгийн тайлан гаргах, гишүүн орон нутгуудын хооронд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх, салбар хороо байгуулах асуудалд санал оруулах Бүгд хурлаас өгөгдсөн үүргийг гүйцэтгэнэ.

### Салбар хороод

Ажлын хэсгийн хорооны туслах хороо бөгөөд Холбооны хурлаас дэвшүүлсэн тодорхой төсөл, зорилтыг саадгүй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор салбар бүрээр хороо байгуулан үйл ажиллагаа явуулж байна.

(Салбар хороодын нэр, зохицуулагч, чиг үүрэг) \*Салбар хороодыг зохицуулагч орон нутаг



#### Эдийн засаг, хүмүүнлэгийн харилцааны хороо<sup>(БНСУ, КЕНСАНБУГ)\*</sup>

Эдийн засаг ба хүмүүнлэгийн харилцааг хослуулан хамтдаа хөгжих, Зүүн хойд Азийн зууныг эхлүүлэх стратеги, хамтын ажиллагааны арга замыг хэлэлцэнэ.



#### Боловсрол, соёлын харилцааны хороо<sup>(ЯПОН УЛС, ШИМАНЭ МУЖ)\*</sup>

Улс орны соёлыг таниулах, хүүхэд залуучуудын болон иргэдийн харилцааны хөтөлбөрөөр дамжуулан харилцан ойлголцол ба нөхөрлөлийн харилцааг нэмэгдүүлж, Зүүн хойд Азийн залуучуудын шинэ харилцааг бүрэлдүүлэхийг эрмэлзэнэ.



#### Байгаль орчны хороо<sup>(ЯПОН УЛС, ТОЯМА МУЖ)\*</sup>

Байгаль орчны талаарх төслийг явуулах ба үүнтэй холбогдуулан орон нутгуудын саналыг авах, тодорхой хэрэгжүүлэх арга замын талаар зөвшилцөж, байгаль орчны чиглэлийн хамтарсан судалгаа, олон улсын байгаль орчныг хамгаалах тухай семинар зэргийг зохион байгуулдаг.



#### Гамшгаас сэргийлэх хороо<sup>(ЯПОН УЛС, ХЕГО МУЖ)\*</sup>

Гишүүн орон нутгуудын гамшгаас сэргийлэх чадварыг сайжруулах зорилгоор мэдээлэл болон туршлага солилцож, гамшгаас сэргийлэх сургуулийг зохион явуулж байна.



#### Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн хороо<sup>(БНХАУ, ШАНЬСИ МУЖ)\*</sup>

Эрчим хүчний холбогдох мэдээлэл, технологийн харилцаа, хамтын ажиллагаа ба уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга замыг бэхжүүлж, бодлогын харилцаа, тэргүүний туршлагыг дэлгэрүүлэх зэрэг ногоон хөгжлийн төлөө гишүүн орон нутаг хооронд төрөл бүрийн харилцаа, хамтын ажиллагааг явуулж байна.



#### Эрдэс баялаг боловсруулалтын хороо<sup>(ОХУ, МАГАДАН МУЖ)\*</sup>

Эрдэс баялаг боловсруулалт, зохицуулалтын үйл ажиллагаагаар дамжуулан харилцан хөгжлийг эрэлхийлж, эрдэс баялаг хамтран боловсруулах технологийн харилцааны тухай судалж байна.



#### Аялал жуулчлалын хороо<sup>(БНХАУ, ХЭНАН МУЖ, НИНШЯГЙН ХОТОН ҮНДЭСТНИЙ ӨЗО)\*</sup>

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын мэдээлэл солилцох, бүсийн хамтын ажиллагааг явуулах зэрэг урт хугацааны үр дүнтэй аялал жуулчлалын механизмыг бүрдүүлэхийг зорьж байна.

#### Далай, загасны аж үйлдвэрийн хороо<sup>(БНХАУ, ШАНЬДУН МУЖ)\*</sup>

Далай, загасны аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, харилцааг нэмэгдүүлэхийн тулд далай загасны аж үйлдвэрийг байгальд ээлтэйгээр хөгжүүлэх загвар боловсруулах, эрдэм шинжилгээний харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, далайг хамгаалах, далайн гамшгийн эсрэг арга хэмжээ авах, гишүүн орон нутаг хооронд үр ашигтай механизмыг байгуулахад анхаарч байна.



#### Био эмчилгээний хороо<sup>(БНСУ, ЧУНЧОНБУГ МУЖ)\*</sup>

Харилцаа, хамтын ажиллагааны сүлжээг бүрэлдүүлж, био шинжлэх ухаан, солонгосын уламжлалт био аж үйлдвэр, эмчилгээний төхөөрөмж үйлдвэрлэл зэрэг эмчилгээний салбарын хамтын хөгжлийн арга замыг эрэлхийлж байна.



#### Газар тариалангийн хороо<sup>(БНСУ, ЖОЛЛАНАМ МУЖ)\*</sup>

Газар тариалангийн бүтээгдэхүүнийг тогтвортой үйлдвэрлэн нийлүүлэхийн тулд байгальд ээлтэй газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, холбогдох мэдээлэл технологийн харилцаа, газар тариалангийн хамтарсан судалгаа, үйлдвэрлэлийн технологи боловсруулан гаргах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.



#### Биеийн тамирын хороо<sup>(ОХУ, САХАГИЙН БНУ)\*</sup>

Гишүүн орон нутаг хооронд спортоор харилцах ба хүүхэд залуучуудын дунд спортын тэмцээн зохион байгуулахаас гадна уламжлалт спортыг сурталчлах үйл ажиллагааг явуулж байна.



#### Тээвэр ложистикийн хороо<sup>(БНХАУ, ХЭЙЛОНЖАН МУЖ)\*</sup>

Зүүн хойд Азийн газарзүй, тээврийн давуу тал болон ложистикийн талаарх сонирхолд үндэслэн Зүүн хойд Азийн тээвэр ложистикийн салбарыг идэвхжүүлж, тээвэр ложистикийн коридор байгуулах, хөгжүүлэх талаар хэлэлцэж байна.



#### Олон улсын боловсон хүчний харилцааны хороо<sup>(БНХАУ, ЖИЛИНЬ МУЖ)\*</sup>

Зүүн хойд Азийн гишүүн орон нутаг хоорондын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрснээр боловсон хүчний эрэлт анхаарал татах болж, гишүүн орон нутгуудын боловсон хүчнийг харилцан солилцох, харилцааны үйл ажиллагааг явуулж байна.



#### Олон улсын цахим худалдааны хороо<sup>(БНХАУ, ХЭНАН МУЖ)\*</sup>

Гишүүн орон нутаг хооронд олон улсын цахим худалдааны хамтын ажиллагааны механизмыг бий болгож, харилцан үйлчлэлийг бэхжүүлэх, тээвэр ложистикийн хамтын ажиллагааг явуулах, холбогдох судалгаа, боловсон хүчнийг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж байна.



#### Шинэчлэлийн хороо<sup>(БНХАУ, ХЭНАН МУЖ)\*</sup>

Зүүн хойд Азийн улс орнуудын шинэчлэлийг хөгжүүлэхийн тулд шинжлэх ухааны шинэчлэлийн хөгжлийн хамтын ажиллагааны тогтолцоо, бүтээгдэхүүний шинэчлэл, идэвхжүүлэлтийн тогтолцоог бий болгохыг зорьж байна.



#### Залуучуудын бодлогын хороо<sup>(ОХУ, КРАСНОЯРСКИЙСКИЙ)\*</sup>

Зүүн хойд Азийн залуучуудыг хөгжүүлэх хамтын ажиллагааг явуулахын тулд байгуулагдсан бөгөөд NEAR-ын гишүүн орон нутгуудын залуучуудын бодлогыг хөгжүүлэх талаар хэлэлцэж байна.



#### Уламжлалт эмийн хороо<sup>(ШААНЬСИ МУЖ)\*</sup>

Зүүн хойд Азийн бүсийн уламжлалт эмийн салбартай холбогдох хамтын ажиллагааны тогтолцоо, харилцааг идэвхжүүлэхийн тулд хамтарсан семинар зохион байгуулах, эмийн компаниудын харилцааг нэмэгдүүлж, уламжлалт эм үйлдвэрлэлийн салбарын боловсон хүчнийг хөгжүүлэх төсөл боловсруулах болон хэрэгжүүлэхийг зорьж байна.

## Хөтөлбөр

### Олон улсын форум

Эрдэмтэн, бизнесмен, төрийн албан хаагч нарын оролцоотой Зүүн хойд Азийн бүсийн хамтын хөгжлийн талаарх бодитой бөгөөд тодорхой арга замыг хэлэлцдэг.



### NEAR-Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал

NEAR Холбооны гишүүн орон нутгуудын харилцаа, хамтын ажиллагааны арга замыг хэлэлцэж туршлагаасаа хуваалцан мэргэжилтнүүдийн харилцааг бэхжүүлэхэд анхаарч байна.



### Зүүн хойд Азийн Залуу удирдагчдын форум

Зүүн хойд Азийн ирээдүйн эзэд болох залуучууд нэг дор цуглан, тогтсон сэдвээр төрөл бүрийн хэлэлцүүлэг явуулж, Зүүн хойд Азийн талаарх ойлголтоо нэмэгдүүлнэ.

### Хүүхэд сурагчдад зориулсан эссэ бичлэгийн уралдаан

Ирээдүйн эзэн болсон хүүхэд залуучуудад Зүүн хойд Азийн харилцаа, хамтын ажиллагаа болон хамтын хөгжлийн тухай алсын хараатай болгоход зориулсан хөтөлбөр юм.



## Холбооны Хэрэг эрхлэх газар

Анх тус Холбоо байгуулагдахад Хэрэг эрхлэх газрыг 2 жилийн хугацаатай ээлжлэн ажиллуулдаг байснаа 2005 онд БНСУ -ын Кёнсанбүг мужийн Пухан хотод байнгын Хэрэг эрхлэх газрыг байгуулан өнөөг хүртэл ажиллаж байна.

Тус газар Ерөнхий нарийн бичгийн дарга, 2 хэлтэс(Төлөвлөлт, олон нийттэй харилцах хэлтэс, Олон улс, хамтын ажиллагааны хэлтэс)-ээс бүрдэх ба Монгол, Орос, Солонгос, Хятад, Япон улсын гишүүн орон нутгуудаас ирсэн төрийн албан хаагч болон тухайн улсуудын хэлний мэргэжилтнүүд нэг баг болон хамтран ажиллаж байна.

Бүгд хурал, Ажлын хэсгийн хорооны болон салбар хорооны хурал зохион явуулахад дэмжлэг үзүүлэх ба гишүүн орон нутгийн Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Олон улсын форум, Зүүн хойд Азийн залуу удирдагчдын форум зохион байгуулахаас гадна Хүүхэд сурагчдад зориулсан эссэ бичлэгийн уралдааныг зохион явуулж байна. Мөн Холбооны түүхэн эмхэтгэл, NEAR News сэтгүүл гаргах болон Холбооны вэбсайтыг ажиллуулж байна.



## Гишүүн орон нутаг

### ОХУ



- ① Буриадын БНУ
- ② Сахагийн БНУ
- ③ Тувагийн БНУ
- ④ Алтайн хязгаар
- ⑤ Забайкаль хязгаар
- ⑥ Красноярск хязгаар
- ⑦ Приморийн хязгаар
- ⑧ Хабаровск хязгаар
- ⑨ Амур муж
- ⑩ Эрхүү муж
- ⑪ Камчатк хязгаар
- ⑫ Магадан муж
- ⑬ Сахалин муж
- ⑭ Томск муж
- ⑮ Кемерово муж
- ⑯ Хакасын БНУ

### Монгол улс



- ① Улаанбаатар хот
- ② Архангай аймаг
- ③ Баян-Өлгий аймаг
- ④ Баянхонгор аймаг
- ⑤ Булган аймаг
- ⑥ Говь-Алтай аймаг
- ⑦ Говьсүмбэр аймаг
- ⑧ Дархан-Уул аймаг
- ⑨ Дорнод аймаг
- ⑩ Дорноговь аймаг
- ⑪ Дундговь аймаг
- ⑫ Завхан аймаг
- ⑬ Орхон аймаг
- ⑭ Өвөрхангай аймаг
- ⑮ Өмнөговь аймаг
- ⑯ Сүхбаатар аймаг
- ⑰ Сэлэнгэ аймаг
- ⑱ Төв аймаг
- ⑲ Увс аймаг
- ⑳ Ховд аймаг
- ㉑ Хэнтий аймаг
- ㉒ Хөвсгөл аймаг

### БНАСАУ

DPR Korea

- ① Хамгёнбүг муж
- ② Насон хот

### БНСУ



- ① Пусан хот
- ② Дэгү хот
- ③ Инчон хот
- ④ Гуанжү хот
- ⑤ Дэжон хот
- ⑥ Ульсан хот
- ⑦ Сэжун хот
- ⑧ Кёнги муж
- ⑨ Канвон муж
- ⑩ Чүнчонбүг муж
- ⑪ Чүнчоннам муж
- ⑫ Жоллабүг муж
- ⑬ Жолланам муж
- ⑭ Кёнсанбүг муж
- ⑮ Кёнсаннам муж
- ⑯ Жэжү муж

### Япон улс



- ① Аомори муж
- ② Акита муж
- ③ Ямагата муж
- ④ Нигата муж
- ⑤ Тояма муж
- ⑥ Ишикава муж
- ⑦ Фүкүи муж
- ⑧ Киото муж
- ⑨ Хёго муж
- ⑩ Тоттори муж
- ⑪ Шиманэ муж

### БНХАУ



- ① Анхүй муж
- ② Хэйлонжан муж
- ③ Хэнан муж
- ④ Хубэй муж
- ⑤ Хунан муж
- ⑥ Жилинь муж
- ⑦ Өвөрмонголын ӨЗО
- ⑧ Ниншягийн Хотон үндэстний ӨЗО
- ⑨ Шаньдун муж
- ⑩ Шаньси муж
- ⑪ Шааньси муж

## Сурвалжлагч гишүүн

- ① Хошимин хот

### Түншлэгч байгууллагууд



#### Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх дэлхийн орон нутгийн захиргаадын байгууллага (R20):

Дэлхийн удирдагчид НҮБ-тай хамтран байгуулсан бөгөөд дэлхийн орон нутгийн захиргаад уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийн тулд нүүрстөрөгчийн гаралт багатай ногоон эдийн засгийн хөгжлийн төсөл, бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

[regions20.org](http://regions20.org)



#### Европын орон нутгийн зөвлөл (AER):


1985 онд байгуулагдсан Европын хамтын хөгжлийн байгууллага бөгөөд 35 орны 230 орон нутаг гишүүнээр элсэн. Зөвлөлийн төв нь Франц улсын Альсас мужийн Страсбург хотод байдаг.

[www.aer.eu](http://www.aer.eu)



#### Тогтвортой хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хот, орон нутгийн захиргаад бүхий дэлхийн 86 орны 1000 гаруй орон нутгаас бүрдэх бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхийн тулд орон нутгийн захиргаадын үүргийг чухалчилдаг.

[www.iclei.org](http://www.iclei.org)



Вьетнам улс